

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН  
ГАЗАР, ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХАРЬЯА

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

**Хүн амын нутагшилт, суурьшил,  
хөдөлмөрийн зах зээлийн судалгаа**

Төслийн дугаар: БС-11/05

*Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн дэргэдэх  
судлаачдын багийн эцсийн тайлан*

2011 оны 12 дугаар сарын

20

## **АГУУЛГА**

### **НЭГ. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЖЛЫН ДААЛГАВАР**

#### **ХОЁР. ХҮН АМЫН НУТАГШИЛТ, СУУРЬШИЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА**

- 2.1. Хүн амын нутагшилт, суурьшлын өнөөгийн байдал
- 2.2. Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал
- 2.3. Хүн ам, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн

#### **ГУРАВ. ХҮН АМЫН НУТАГШИЛТ, СУУРЬШЛЫН ХЭТИЙН ТӨЛӨВ, ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЦААШДЫН ХАНДЛАГА**

- 3.1. Хүн ам, хөдөлмөрийн нөөцийн өсөлтийн цаашдын чиг хандлага (2016-2030 оноор)
- 3.2. Үйлдвэрлэлийн хөгжил, төвлөрөлтэй уялдсан хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэргэжилтэй ажиллах хүчний судалгаа
  - 3.2.1. Уул уурхайн салбар
  - 3.2.2. Дэд бүтцийн салбар.
  - 3.2.3. Хүн амын нутагшил, суурьшил нэмэгдэх хот суурин газруудад шинээр бий болох ажлын байрны тооцоо.
  - 3.2.4. Ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн нэгдсэн тойм
- 3.3. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн төвүүдийн хэтийн төлөв
  - 3.3.1. Хэт төвлөрлийг сааруулж, шинэ хотжилтыг үүсгэн “Нисэхийн хотхон”-ыг төлөвлөн хөгжүүлэх
  - 3.3.2. Мэдээлэл, технологийн парк, оюуны хотхон
  - 3.3.3. Уул уурхайн үйлдвэрлэл дагасан хүн амын суурьшлын төвүүд
  - 3.3.4. Уул уурхай дагасан хотжилт

#### **ДӨРӨВ. БОДЛОГЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

- 4.1. Судалгааны дүгнэлт
- 4.2. Судалгааны зөвлөмж

Хавсралт № 1. Монгол Улсын нийслэл, дүүрэг, аймаг, сумын хүн амын тоо (1989-2010 он)

Хавсралт № 2. Бүс, аймгийн хүн амын тооны өөрчлөлтийн газрын зураг

Хавсралт № 3. Газар тариалангийн аж ахуй эрхэлдэг сумын хүн амын суурьшлын судалгаа

Хавсралт № 4. Шинэ төмөр зам барихад шаардлагатай ажиллах хүчний тойм

Хавсралт № 5. Ажиллах хүчний шинээр бий болох эрэлтийн тойм судалгаа (2010-2015 он)

## **НЭГ. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЖЛЫН ДААЛГАВАР**

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол улсын хүн амын шилжилт хөдөлгөөн, нутагшилт суурьшил, хөдөлмөрийн зах зээлийн байдалд дүн шинжилгээ хийж, бодлогын зөвлөмж, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулахад орших бөгөөд энэхүү зорилгод хүрэхийн тулд дараахь зорилтыг тодорхойлж байна. Үүнд:

- ❖ Хүн ам, хөдөлмөрийн зах зээлийн онол, арга зүйг судалгаанд ашиглах;
- ❖ Монгол улсын хүн ам, хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг тооцож, үнэлэлт дүгнэлт өгөх;
- ❖ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн өнөөгийн байдал, хэтийн төлөвийг хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, нутагшил суурьшил, үйлдвэржилтийн төлөв, шинэ ажлын байр, ажиллах хүчний эрэлт хэрэгцээ цаашдын хандлагад тулгуурлан судлах;
- ❖ Монгол улсын ажиллах хүчний хэрэгцээ, хүн амын шилжилт хөдөлгөөнийг тэргүүлэх салбар, нутагшилтын бүсээр судалж, богино болон урт хугацааны төлөвлөлт хийж, таамаглал дэвшүүлэх юм.

### **Тогтвортой хөгжил бүхий хүн амын нутагшилт суурьшлын бодлогын шинэ хандлага**

1990 он гарснаас дунд зэргийн болон хөгжиж буй орнуудад хотжилт эрчимтэй хөгжжээ. 2009 онд дэлхийн нийт хүн амын 50.0 хувь хотод суурьших болсон бөгөөд ялангуяа том хотуудын хүн амын энэхүү эрчимтэй өсөлтийг дагаад хүрээлэн буй орчны доройтол, хотын дэд бүтцийн даац хэтрэх, хот, хөдөө орон нутгийн хөгжлийн ялгаа ихсэх, хотын ажилгүйдэл, ядуурал, бүс нутгийн тэнцвэрт бус хөгжил, ядуусын хороолол тэлэх зэрэг нийгэм-эдийн засгийн сөрөг үр дагавар ихээр гарсан. Иймэрхүү сөрөг үр дагаврыг хамгийн ихээр мэдэрсэн орнууд нь Латин Америкийн Мексик, Бразил, Африкийн Египет, Ардчилсан Конго, Сенегал, Кот Д'Ивуар, Нигери, Азийн Бангладеш, Монгол, Энэтхэг, Пакистан, Индонез зэрэг орнууд юм. Иймд хүн амын тогтвортой хөгжил бүхий нутагшилт суурьшлын бодлого шинээр гарч ирсэн. Үндсэн санаа нь хэт том хотын төвлөрлийг сааруулахын тулд дунд хотуудыг дэмжих, мөн том хотын дэргэд шинэ хот байгуулах хандлага юм<sup>1</sup>.

---

<sup>1</sup> Sustainable development of human settlements: Achievements and challenges in housing and urban policy in Latin America and the Caribbean, UN, 1998


## ХОЁР. ХҮН АМЫН НУТАГШИЛТ, СУУРЬШИЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

### 2.1. ХҮН АМЫН НУТАГШИЛТ, СУУРЬШЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын хүн ам 1918 онд 647.5 мянга байсан бол 2010 оны байдлаар 2754 мянгад хүрч, ХХ зуунд бараг дөрөв дахин өсчээ. Томоохон өсөлт нь 1960 ба 1970-аад онд болж, тухайн үед хүн амын жилийн дундаж өсөлтийн коэффициент 3.0 хувьд дөхөж, хүн ам 25 хүрэхгүй жилийн дотор хоёр дахин өссөн ажээ. Эдгээр жилүүдэд төрөлт ихтэй байсантай холбогдон сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн насны залуучууд олноор нэмэгдэж байна. 1990 оноос хойш улс оронд үүссэн эдийн засгийн хямралтай холбогдон хүн амын өсөлт буурсан нь үндсэндээ төрөлтийн огцом бууралтын үр дүн байлаа.


Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын үндсэн 2 хэлбэр нь хот, хөдөө бөгөөд хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр хотжилт эрчимтэй явагдаж 2010 оны байдлаар 67.9 хувьд хүрээд байна. Тодруулбал нийт хүн амын 44 хувь нийслэлд (агломераци буюу том хот дагасан), 30 хувь нь нийт 350 хот, суурин газарт (Шугаман буюу авто замын тэнхлэг дагасан), үлдэх 26 хувь нь хөдөөд (жигд буюу засаг захиргааны нэгжүүд дагасан) амьдарч байна (Зураг 1).

Зураг 1. Монгол Улсын хүн амын суурьшлын үндсэн 3 хэлбэр



Монгол Улсын нийт хүн амын 41.4 хувь буюу нийт хотын хүн амын 65.4 хувь нь (1151.0 мянган хүн) нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна (Зураг № 4 болон Зураг № 5). Монгол Улсын хүн амын нутагшилт суурьшлын хэлбэрийг 1918-2010 оны хооронд аваад үзэхэд ХАА-н салбарт ажиллагсад буюу хөдөөгийн хүн амын тоо харьцангуй тогтвортой байсан нь хуурай эмзэг бэлчээрийн экосистемтэй манай орны хувьд бэлчээрийн даац, түүнд тохирсон малын тооноос шууд хамааралтай юм. Өөрөөр хэлбэл хөдөөгийн хүн амын цэвэр өсөлт ихтэй ч бэлчээрийн даацаас хамаарч цаашид ч малчин өрхийн тоо өнөөгийн түвшинд тогтвортой байхыг харуулж байна.

## Зураг № 6. Монгол Улсын хүн амын өсөлт, байршлаар



Монгол Улсын хүн амын суурьшлын хэтийн төлөвөөс харахад хүн ам өсөн нэмэгдэхийн хэрээр хотжилтын түвшин нэмэгдэх бөгөөд харин хөдөөгийн хүн амын тоо харьцангуй тогтвортой байх хандлага байна (Зураг 5).


### Хүснэгт № 1. Хүн амын нутагшилт, суурьшлын одоогийн байдалд хийсэн SWOT дүн шинжилгээ

<b>Давуу тал</b>	<ul style="list-style-type: none"> <li>Хүн амын нутагшилт, суурьшил, хөдөлгөөнд тавигддаг байсан засаг захиргаа, хууль эрх эдийн засгийн хориг саад багассан</li> <li>Зам тээвэр, эрчим хүчний харьцангуй сайн үндсэн сүлжээ бүрэлдсэн</li> <li>Эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн суурь үйлчилгээний дэд бүтэц бүрэлдсэн</li> <li>Хүн амын нутаг дэвсгэрээр жигд тархан суурьшсан</li> <li>Хүн амзүйн цонх үе нээгдсэн</li> <li>Уул уурхай, үйлдвэрлэлийн хөгжлийг дагаад суурьшлын шинэ төвүүд бий болох таатай нөхцөл бүрдсэн</li> </ul>
<b>Сөрөг тал</b>	<p><b>Хот байгуулалтын хувьд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Хүн амын хэт төвлөрөл (1 хотод нийт хүн амын 44.0 хувь), хэт сарнил (350 гаруй хот, суурин газарт нийт хүн амын 30.0 хувь амьдардаг)</li> <li>Орон нутагт хүн ам, зах зээлийн зохистой төвлөрөл бүрдээгүйгээс ажилгүйдэл, ядуурал нэмэгдсэн</li> <li>Хөдөөнөөс төвийг чиглэсэн их нүүдлээс шалтгаалж, нийслэлд хүн амын хэт төвлөрөл үүссэнээр авто зам, ус, цахилгааны хангамж зэргээр дэд бүтэцэд сөргөөр нөлөөлөх болсон.</li> </ul> <p><b>Нийгмийн хувьд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Засаг захиргааны хэт олон жижиг нэгжид хуваагдсанаар цус ойртолт зэрэг хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг</li> <li>Хэдий засаг захиргааны нэгж тус бүрт эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний дэд бүтэц байгаа ч чанар, хүртээмж муу учир өртөг зардал ихтэйгээр эдгээр үйлчилгээгээр төв рүү таталцдаг.</li> <li>Гадаадад 120.0 мянга гаруй монгол иргэн харьцангуй бага цалин хөлстэйгээр ажиллаж, амьдарч буй бол монголд 20.0 мянга орчим гадаадын иргэн харьцангуй өндөр цалин хөлстэй ажиллаж байна. Өөрөөр хэлбэл хүн ам, хөдөлмөрийн нөөц болон эдийн засгийн гадагш чиглэсэн урсгал харьцангуй их байна.</li> </ul>

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

	<p><b>Эдийн засгийн хувьд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Аймаг, сум жижигрэх тусам 1 хүнд ногдох эрүүл мэнд, боловсрол зэрэг төрийн үйлчилгээний өртөг зардал нэмэгдэж, эсрэгээр тэдгээрийн чанар, хүртээмж тааруу байна.</li> <li>- Төсвийн үрлэгэн тогтолцоо</li> <li>- Эдийн засгийн хувьд аймаг, сумд нь улсын төсвөөс бүрэн хараат байдалтай</li> </ul> <p><b>Хууль, эрхзүйн орчны хувьд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Сум, орон нутгийн бие даан хөгжих, нутгийн өөрөө удирдах эрхзүйн орчин маш сул</li> <li>- Сум, орон нутгийн байгууллагын төсвийн эрх мэдэл бага.</li> </ul> <p><b>Экологийн хувьд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажиллах хүчний дийлэнх буюу 34.0 хувийг эзлэх хөдөө аж ахуй, тэр дундаа мал аж ахуйн салбар уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг болж, энэ салбарт ажиллагсдын тогтвортой амьжиргаанд сөргөөр нөлөөлөх болсон.</li> <li>- Нийт сумын тал орчим хувьд улирлын бэлчээр дутмаг.</li> <li>- Усны хомсдол нэмэгдэж, усны сав газрын хэмжээнд олон сумд хамрагддаг нь тэдгээрийг усны нэгдсэн менемент хийхэд сул тал болдог.</li> </ul>
<p><b>Аюул занал, эрсдэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Нийт хүн амын 44.0 хувь оршин суух нийслэл Улаанбаатар хотод хүрээлэн буй орчны бохирдол, дэд бүтцийн ачаалал ихэссэнээс хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхээ эдлэхэд ноцтой аюулд хүргэж байна.</li> <li>- Оюутолгой, Тавантолгой зэрэг стратегийн томоохон ордуудыг түшиглэсэн хот байгуулалтын бодлого байхгүйгээс ажилчид тогтвор суурьшилтай ажиллах, гэр бүлийн орчноос хол амьдарч байгаагаас үүдэлтэй гэр бүл салалт зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд гарч байна.</li> <li>- Үйлдвэрлэлийн хөгжил, төвлөрлийг даган сүүлийн жилүүдэд нэмэгдсээр буй гадаадын ажиллах хүчний өсөлт, дотоодын ажиллах хүчний эрэлт хэрэгцээний хомсдол</li> <li>- Орон нутгийн хөгжлийг уясан төсвийн хараат байдал</li> </ul>
<p><b>Боломж</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүн амд төрийн үйлчилгээг ойр хүргэх үүднээс аймаг, сум бүр дээрхи одоогийн төрийн үйлчилгээний (эрүүл мэнд, боловсрол зэрэг) дэд бүтцийг тогтвортой ашиглах шаардлагатай.</li> <li>- Уул уурхай, үйлдвэрлэлийн өсөлтийг даган их хөрөнгийг үр ашигтай шингээх чадавхи бүхий шинэ хотыг төлөвлөн хөгжүүлбэл нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулж чадна.</li> </ul>

Монгол улсын хүн амын өсөлтийг насны бүтцээр авч үзвэл 2010 оны байдлаар Монгол Улсын хүн ам 1.4 хувиар өсч байхад хөдөлмөрийн насны хүн ам 3.0 хувиар өссөн ажээ (Зураг № 3).




Эх сурвалж: ҮСХ. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2010, 2011.

Хэдийгээр хүн амд эзлэх 65 ба түүнээс дээш насны хүн амын хувийн жин ирээдүйд өндөр түвшинд хүрэх боловч түүнээс өмнө Монгол улс эдийн засгийн хөгжил, нийгмийн тогтолцоон дахь хөрөнгө оруулалт болон хүний хөгжилд маш таатай орчинг бүрдүүлдэг “хүн ам зүйн цонх” нээгдэх үеийг туулж өнгөрүүлэх болно. Энэ нь тэжээлгэгч (залуу (0-14) ба хөгшин (65+) насны бүлгийн хүн ам) хүн амын

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

тооны бууралт ба эдийн засгийн идэвхтэй (15-64 насны хүн ам) хүн амын өсөлтөөр илэрхийлэгдэж байгаа хүн ам зүйн ачааллын бууралтаас тодорхой харагдаж байна. Хүн ам зүйн ачаалал нь Монгол Улс дахь тэжээлгэгч хүн амын үндсэн хэсгийг залуу насны хүмүүс бүрдүүлж байгааг илтгэн харуулж байна.

Хөдөөнөөс төвийг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр хотжилтын түвшин эрчимтэй өсч ирсэн бөгөөд 2010 оны байдлаар нийт хүн амын 63.3 хувь хотод суурьшиж байна.



Эх сурвалж: ҮСХ, 2011. Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2010

## Хүснэгт № 2.

### Томоохон хот, сум, суурин газрын хүн амын тооны өөрчлөлт

№	Хот, сум, суурин газрын нэр	Хүн амын тоо			Өсөлт
		1989	2004	2010	2010/1989
<b>1. Уул уурхай дагасан хот, сум суурин газар</b>					
1.	Гурвантэс - Овоот толгойн нүүрс, Өмнөговь	2721	3389	4243	56.0%
2.	Ханбогд - Оюутолгойн зэс, алт, Өмнөговь	1892	2577	9522	5 дахин
3.	Цогтцэций - Тавантолгойн нүүрс, Өмнөговь	1967	2102	7366	3.7 дахин
4.	Эрдэнэт - Зэсийн орд, Орхон аймаг	52900	80858	84950	60.6%
5.	Төмөртэйн цайрын орд - Баруун-Урт-Сүхбаатар	16547	13924	16734	1.1%
6.	Налайх - нүүрсний орд	22833	25694	31458	37.8%
7.	Багануур - нүүрсний орд	13669	24606	26905	2 дахин
8.	Шивээговь-Шивээ-Овоогийн нүүрсний орд, Говьсүмбэр		2628	2947	12.1%
9.	Матад-Тамсагбулагийн газрын тос,	2190	2406	2526	15.3%

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

	Дорнод				
10.	Бат-Өлзий – алт - Өвөрхангай	4042	5932	6318	56.3%
11.	<b>Уянга – алт - Өвөрхангай</b>	<b>5832</b>	<b>10003</b>	<b>9498</b>	<b>62.9%</b>
12.	Бөмбөгөр – алт - Баянхонгор	2033	2508	2767	36.1%
13.	Заамар – алт - Төв	3494	5519	5084	45.5%
	<b>Нийт</b>	<b>130120</b>	<b>182146</b>	<b>210318</b>	<b>61.6%</b>
<b>2. Төмөр замын тэнхлэг болон хилийн боомт дагасан хот, суурин газрууд</b>					
1.	Сайншанд	15877	18675	21100	32.9%
2.	Сүхбаатар	20247	19466	21460	6.0%
3.	Чойр	7367	8798	10697	45.2%
4.	Дархан-Уул	63211	74277	77547	22.7%
5.	Замын-Үүд-Дорноговь	1463	7763	13800	8.4 дахин
6.	Алтанбулаг-Сэлэнгэ	3741	3783	5015	34.1%
7.	Булган-Ховд	8870	9344	9266	4.5%
8.	Эрдэнэцагаан-Бичигт -Сүхбаатар	4734	5847	6483	37.0%
9.	хóёóóíðíðíð	2326	1483	1609	-31.8%
10.	Õàíõ	1218	2341	2489	2 дахин
	<b>Нийт</b>	<b>129054</b>	<b>151777</b>	<b>169466</b>	<b>31.3%</b>
<b>3. Аялал жуулчлалын төв сум, суурин газар</b>					
1.	Хархорин	11329	12546	12882	13.7
2.	Õàðããë	5897	2806	2973	-50.6
	<b>Нийт</b>	<b>17226</b>	<b>15352</b>	<b>15855</b>	<b>-8.0</b>
<b>4. Газар тариалангийн үйлдвэрлэл дагасан сум, суурин газар</b>					
	<b>Нийт Төв, Сэлэнгэ аймгийн 17 сум</b>	<b>61764</b>	<b>52848</b>	<b>58432</b>	<b>-5.4</b>
5.	Улаанбаатар	548393	915531	1240000	2.2 дахин
<b>Бүгд (Улаанбаатар орсон)</b>		<b>886557</b>	<b>1317654</b>	<b>1694071</b>	<b>91.1</b>
<b>Бүгд (Улаанбаатар ороогүй)</b>		<b>338164</b>	<b>402123</b>	<b>464071</b>	<b>37.2</b>

Эх сурвалж: ҮСХ. Хүн ам, орон сууцны 1989, 2000, 2010 оны тооллого

1990 онд зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш Монгол улсын хүн амын нутагшилт суурьшлын тогтолцоонд гарсан өөрчлөлтийг дараахь байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Монгол улсын нийслэлийн хүн ам бараг 2.2 дахин өссөнөөр хүн амын хамгийн их өсөлттэй суурин газар болжээ.
- Уул уурхайн үйлдвэрлэл дагасан хот, сум, суурин газрын хүн ам 1990-2010 онд 61.6 хувиар өссөн бөгөөд тэр дундаа Ханбогд сумын хүн ам 5 дахин, Цогтцэций сумын хүн ам 4 дахин, Багануур хотын хүн ам 2 дахин тус тус өссөн байна (Хүснэгт № 2, Зураг № 6).
- Мал аж ахуйн үйлдвэрлэл дагасан сум, суурин газар болон автозам, төмөр замын тэнхлэг дагаагүй засаг захиргааны төв болох аймгийн төвийн хүн ам дээрх хугацаанд буурсан бол газар тариалангийн үйлдвэрлэл дагасан сум, суурин газрын хүн ам бага буурсан буюу харьцангуй тогтвортой байна (Хүснэгт № 2, Зураг № 6).




Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.



Эх сурвалж: ҮСХ. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2010, 2011 он.

Монгол Улсын хүн ам, хөдөлмөрийн нөөцийн тооны өөрчлөлтөөс харахад дээрх хугацаанд Улаанбаатарын бүс огцом өсөлттэй, Төвийн бүсийн хүн ам тогтвортой өсөлттэй байгаа бол Баруун болон Зүүн бүсийн хүн ам буурсан, Хангайн бүсийн хүн ам дээрх хугацааны эхний хагаст (1989-2004) өсөөд сүүлийн хагаст (2004-2010) буурчээ. Харин аймгаар авч үзвэл 1989-2010 онд 21 аймгаас Говьсүмбэр аймаг 79.0 хувь, Орхон аймаг 71.4 хувь, Өмнөговь аймаг 44.0 хувь, Дорноговь аймаг 20.1 хувь, Дархан-Уул 18.1 хувиар тус тус өссөн бол 8 аймгийн хүн ам буурсан ажээ (Зураг № 9).

**Зураг № 9. Бүс, аймгуудын хүн амын тооны өөрчлөлт, 1989, 2004, 2010 онд**



Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

Дүгнэж үзвэл, хүн ам нь буурсан аймгийн тоо 1989-2004 онд 3 байсан бол 2004-2010 онд 16 болж өссөн бөгөөд Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр, Өмнөговь, Дорноговь зэрэг 5 аймгийн хүн ам 2004-2010 онд өссөн нь сүүлийн 6 жилд хүн амын шилжилт хөдөлгөөнөөс хамаарч бусад аймгуудын хүн ам ихээр буурсантай холбоотой юм.

## 2.2. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Ажиллах хүчний 2010 оны судалгааны дүнгээр Монгол Улсын эдийн засгийн идэвхтэй хүн ам 1147.1 мянга байгаагаас 1033.7 мянга буюу 90.1 хувь нь ажиллагчид, 113.4 мянга буюу 9.9 хувь нь ажилгүй иргэд байна.

### Хүснэгт № 3.

#### Хүн амын ажил эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2000	2002	2004	2006	2008	2010
Хөдөлмөрийн насны хүн амын тоо	1347.4	1439.2	1531.1	1619.6	1688.7	1843.5
Ажиллах хүч	847.6	901.7	986.1	1042.8	1071.6	1147.1
Ажиллагчдын тоо	809.0	870.8	950.5	1009.9	1041.7	1033.7
Бүртгэлтэй ажилгүйчүүд	38.6	30.9	35.6	32.9	29.8	38.3
Ажил эрхлээгүй хүн амын тоо	282.7	265.8	248.3	257.6	267.5	113.4
Хөдөлмөрийн насны суралцагчдын тоо	153.7	196.5	218.0	243.3	270.5	285.5
Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн амын тоо	77.9	85.8	89.1	82.3	83.7	84

Эх сурвалж: ҮСХ, БСШУЯ, НХХЯ, МБГ. 2000-2010. Салбарын статистик үзүүлэлтүүд


Хүн амын насны бүтцийн онцлогоос шалтгаалж нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байгаа нь ажиллах хүчний эрэлтийг нэмэгдүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэхийг зүй ёсоор шаардаж байна (Зураг № 10).



Эх сурвалж: ҮСХ. Ажиллах хүчний судалгаа 2010. 2011 он.

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

Түүнчлэн хөдөлмөрийн насны хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2010 оны байдлаар 67.4 хувь болж нэмэгдсэн, мөн ажилгүй иргэдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү их байгааг харгалзан эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах нь чухал зорилт болохыг харуулж байна (Зураг № 11).



Эх сурвалж: ҮСХ. Ажиллах хүчний судалгаа 2010, 2011 он.

### Салбарын хөгжил ба хөдөлмөр эрхлэлт.

Нийт ажиллагсдыг салбараар авч үзвэл, хөдөө аж ахуйн салбар 34.0 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбар 14.0 хувь, боловсролын салбар 8.0 хувийг тус тус эзэлж байна (Зураг № 12). Ажиллагсдын тоогоор хамгийн том салбар болох хөдөө аж ахуйн салбар нь уур амьсгалын болон газар ашиглалтын өөрчлөлтөд эмзэг бөгөөд зудын дараа олон мянган малчид малгүй болж ажилгүйдлийг улам нэмэгдүүлдэг нь өмнөх жилүүдийн зудын дараа тодорхой харагдсан билээ.

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.



Эх сурвалж: ҮСХ. Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2010, 2011 он.

### Боловсрол ба хөдөлмөрийн зах зээл.

2010/2011 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 113 их, дээд сургууль, коллежэд 170.1 мянган оюутан суралцаж байна. Их, дээд сургуулийн 100 нь нийслэл хотод, 13 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Нийт сургуулиас 16 нь төрийн өмчийн, 92 нь төрийн бус өмчийн, 5 нь гадаадын их сургуулийн салбар байна. Нийт суралцагчдын 104431 нь төрийн өмчийн, 65306 нь төрийн бус өмчийн, 389 нь гадаадын их сургуулийн салбар сургуульд суралцаж байна. Улсын хэмжээгээр 2010/2011 оны хичээлийн жилд Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн 60 төвд 46071 сурагч суралцаж байна.

2010 оны байдлаар их, дээд сургуулийг 34.0 гаруй мянган оюутан төгссөн хэдий ч тэдний дөнгөж 40.0 хувь нь ажлын байртай болдог гэсэн судалгаа байна. Дээд боловсролтой ч их, дээд сургууль төгсөгчдийн тэн хагас нь ажилгүйчүүдийн эгнээнд шилжиж байна. Хөдөлмөрийн зах зээл дээр 10.0 мянга орчим ажлын байр сул байгаа ч дээд боловсролтой хүмүүсийн мэргэжил тохирохгүй байна.

### Хүснэгт № 4. Бүх шатны сургалтын байгууллагыг төгсөгчдийн тоо

Сургалтын байгууллагын ангилал	2006/2007	2007/2008	2008/2009	2009/2010
<b>ЕБС төгсөгчид</b>	99.9	96.2	89.8	90.2
Үүнээс: эмэгтэй	52.6	50.7	47.5	46.9

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

<b>МСҮТ-ийг төгсөгчид</b>	7.0	8.7	11.2	15.1
Үүнээс: эмэгтэй	3.4	4.0	5.3	7.3
<b>Их, дээд сургууль, коллеж төгсөгчид</b>	25.9	29.6	33.0	34.2
Үүнээс: эмэгтэй	16.9	19.4	21.0	22.1
<b>БҮГД</b>	<b>132.8</b>	<b>134.5</b>	<b>134.0</b>	<b>139.5</b>
Үүнээс: эмэгтэй	72.9	74.1	73.8	76.3

Эх сурвалж: ҮСХ. Монгол Улсын статистикийн эмхэтгэлүүд 2006-2010

БСШУЯ, МБГ. Боловсролын салбарын үзүүлэлтүүд 2010, 2011 он

НХХЯ. Хүн ам, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн үзүүлэлт 2010,

2011 он

Их, дээд сургуулиас гадна мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд 47918 оюутан суралцаж, тэдгээрийг жилд 15.0 мянга гаруй залуучууд төгсөж, төгсөгчдийн 70.0 хувь нь ажлын байртай болдог ажээ. Өнөөдрийн байдлаар хөдөлмөрийн зах зээлд уул уурхай, зам тээвэр, барилга, худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэлийн салбарын мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээ өндөр байна. Тэр дундаа хүнд машин, механизмын оператор, гагнуурчин, цахилгаанчин, сантехникч, барилгын өргөн мэргэжилтнүүд хамгийн эрэлттэй байна.

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд судалгааны үндсэн дээр мэргэжилтнүүдээ бэлтгэдэг ч багшлах боловсон хүчин, сургалтын материаллаг бааз, дадлагын газрын хувьд дутагдалтай тул хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг хангаж чадахгүй байна.

#### **Хүснэгт № 5. Хөдөлмөрийн зах зээл дээрхи ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлт, мянган хүнээр**

<b>№</b>	<b>Ажиллах хүчний эх үүсвэр</b>	<b>Төгсөгч буюу хөдөлмөрийн зах зээлд шилжигсдийн тоо</b>	<b>Ажлын байртай болсон хүний тоо</b>
1	Их дээд сургууль, коллеж төгссөн залуучуудын тоо	34.2	13.6
2	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгсөгчдийн тоо	15.1	10.5
3	Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн тоо	3.0	
4	Бусад /цэрэг, хорих, гадаад орноос г.м. /	6.0	
5	Хөдөлмөрийн байгууллагад бүртгэлтэй ажилгүйчүүд		38.3
6	Хөдөлмөр эрхлээгүй иргэд		113.4
7	Ажиллагчдын жирийн урсгал хөдөлгөөнөөс ажилгүй болсон дахин ажилд хуваарилагдах хүний тоо		30
8	<b>Одоо хөдөлмөрийн зах зээлд байгаа ажлын байр</b>		<b>10</b>
	<b>БҮГД</b>	<b>240.0</b>	<b>24.1</b>

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

Эх сурвалж: НХХЯ. Хүн ам, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн үзүүлэлтүүд 2010, 2011 он. ҮСХ. Монгол Улсын статистикийн эмхэтгэлүүд 2006-2010. БСШУЯ, МБГ. ЧБоловсролын салбарын үзүүлэлтүүд 2010, 2011 он.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг бүрэн хангасан ажил эрхлэлтийг зохион байгуулна гэж үзвэл 2011 оны байдлаар 240.0 мянган ажлын байр шаардлагатай байна. Мэргэжил олгох сургалтын байгууллагад олгож байгаа мэргэжлийн төрөл хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй тэр болгон тохирохгүй байна. Мэргэжлийн боловсролын байгууллагыг жил тутам төгсөгчдийн 50.0-70.0 хувь нь ажлын байраар хангагдаж байгаагаас үндэслэн мэргэжлийн боловсролын байгууллагад суралцагчдын мэргэшлийн ангилал, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хоорондын уялдаа сул байна гэсэн дүгнэлтийг хийж болно.

Улсын хэмжээнд их, дээд сургууль, коллеж зэрэг дээд мэргэжил олгох сургуулийн 88.5 хувь нь зөвхөн Улаанбаатар хотод төвлөрсөн нь мэргэжил олгох сургалтын чанарыг сайжруулах өрсөлдөөнийг бий болгох сайн талтай ч мэргэжлийн төрөл ижил төстэй, хөдөлмөрийн зах зээлийн захиалгагүй, олон жижиг сургуулиуд нэг мэргэжлээр сургалт явуулж байгаа нь боловсролын салбарт оруулж буй хөрөнгө оруулалтыг үр ашиггүй болгоход хүргэж байна.

#### Хүснэгт 6. Их, дээд сургууль, коллежид суралцагсдын тоо

№	Мэргэжлийн салбар, чиглэл	Суралцагчдын тоо	
		Бүгд	Нийт дүнд эзлэх
1.	Боловсролын салбар	22471	13.2%
2.	<b>Хүмүүнлэгийн салбар</b>	<b>14757</b>	<b>8.6%</b>
3.	<b>Нийгмийн салбар</b>	<b>58649</b>	<b>34.5%</b>
4.	Байгалийн ухааны салбар	11932	7.0%
5.	Техник, технологийн салбар	29984	17.6%
6.	Хөдөө аж ахуйн салбар	4902	2.9%
7.	Анагаах ухааны салбар	17995	10.6%
8.	Үйлчилгээний салбар	8843	5.2%
9.	Бусад	593	0.3%
Бүгд		<b>170126</b>	<b>100%</b>
Үүнээс:	Гадаадын болон харьяалалгүй суралцагчид	1039	0.6%
	УБ, Дархан, Орхон хотын харьяат	84778	49.8%
	Хөдөө орон нутгийн харьяат	84312	49.6%

Эх сурвалж: БСШУЯ, ҮХХ. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд, сургууль, коллежид суралцагсдын судалгаа 2010, 2011 он.

Монгол улсын эдийн засгийн өнөөгийн хандлага уул уурхай, эрдэс баялаг, эрчим хүч, зам тээвэр, барилгын салбар руу чиглэсэн хандлагатай хөгжиж байхад их, дээд сургууль, коллежид суралцагчдын 62.0% хувь буюу 104720 нь нийгэм, хүмүүнлэг, боловсрол, үйлчилгээний салбарын чиглэлээр суралцаж байгаа нь өнөөгийн болон ойрын ирээдүйн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангахгүйд хүргэж байна. Нөгөө талаар анх байгуулагдахдаа салбарын чанартай сургалт явуулахаар байгуулагдсан, аймаг орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа МСҮТ-

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

үүдийн мэргэжлийн төрлүүд нь анхны үндсэн үйл ажиллагаанаасаа гажиж, бараг бүх аймагт ижил төрлийн мэргэжлээр сургалт явуулж байна.

### Үйлдвэрлэлийн хөгжил ба хөдөлмөр эрхлэлт.

Дотоодын түүхий эдийг түшиглэх нь аж үйлдвэржүүлэх бодлогын чухал хүчин зүйл юм. Манай улс хөдөө аж ахуйн гаралтай болон уул уурхайн түүхий эдийг дотооддоо боловсруулснаар аж үйлдвэрийг хөгжүүлэх, экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэн нэр, төрлийг олшруулах, ажлын байр олноор бий болгох, бүтээмж нэмэгдүүлэх, нэмүү өртөг бий болгож үндэсний орлогыг өсгөх, татварын суурийг өргөтгөх, ядуурлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

### Хүснэгт 7. Үйлдвэрлэлийн салбар ба хүн амын тооны өөрчлөлт

Нийслэл, аймгууд	Аж үйлд/бүт борлуулалт, тэрбум төг			ДНБ, тэрбум төг			Хүн амын тоо, мянгаар		
	2004	2010	Өсөлт	2004	2010	Өсөлт	2004	2010	Өсөлт
Улаанбаатар	604.1	2370	4 дахин	1023.4	5174.1	5 дахин	915.6	1240	35.0%
Орхон	434.9	1208.3	3 дахин	286.9	862.7	3 дахин	78.4	90.7	15.0%
Сэлэнгэ	33.2	211.9	7 дахин	43.1	251.6	6 дахин	91.5	97.6	8.0%
Өмнөговь	19.9	352.6	17 дахин	25.9	182.4	8 дахин	47.8	61.3	27.0%
Дархан-Уул	36.3	109	3 дахин	42.3	155	3.5 дахин	90.4	94.6	5.0%
Сүхбаатар	3.8	103.6	30 дахин	30.1	111.5	3.4 дахин	53.9	51.3	- 6.0%
Дорноговь	1.7	3.3	2 дахин	23.8	61	2.8 дахин	51.6	58.6	14.0%

Эх сурвалж: ҮСХ. Монгол Улсын статистикийн эмхэтгэлүүд 2004-2010, ҮСХ. Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүн, 2011 он.

Үйлдвэрлэлийн болон хүн амын өсөлт өндөр байгаа нийслэл болон зарим аймгуудийг авч үзвэл жилд хүн ам дунджаар 1.0 хувиар өсөхөд ДНБ 13.1%, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 10.4%-иар өссөн зүй тогтол харагдаж байна. Үүнээс дүгнэхэд, хүн амын төвлөрлийг дагаж эдийн засаг өсдөг, эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжлийг дагаж хүн ам өсдөг зүй тогтлыг харж болохоор байна (Хүснэгт № 7).

Хөдөлмөр эрхлэлт, үйлдвэрлэлийн салбарыг хөдөлмөрийн бүтээмжээр буюу 1 хүнд ногдох жилийн үйлдвэрлэлийн хэмжээгээр авч үзвэл уул уурхайн салбар 52.9 сая төгрөг, санхүү даатгал 10.5 сая төгрөгөөр тус тус тэргүүлж байна (Зураг 14). Үүнээс дүгнэхэд, уул уурхайн салбар тэргүүлэх салбар болон хөгжиж, бусад салбарыг тэтгэн урагшлуулах бололцоотой нь харагдаж байна.



Эх сурвалж: ҮСХ. Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2010, 2011 он.

Иймээс өргөн уудам нутагтай манай орны хувьд аж үйлдвэрийн хөгжлийн асуудлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан тухайн орон нутгийн түүхий эд, харьцангуй давуу талд тулгуурлан үйлдвэрлэлийн чиглэлийг тогтоох, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн цогцолборыг зохион байгуулалттай хөгжүүлэх замаар үйлдвэрлэлийн эрчимтэй хөгжлийг хангаж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшинг ойртуулах нь тулгамдсан зорилт болж байна.

### 2.3. ХҮН АМ, АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

**Хүн ам, ажиллах хүчний дотоод шилжилт хөдөлгөөн:** Шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр аймаг, нийслэлийн хүн ам өөрчлөгдөж байгааг Зураг № 16–аас тодорхой харж болохоор байна. Аймгийн нийт хүн ам 1990-2000 онд бага зэрэг өссөн бол 2000-2010 онд ихэнх аймгийн хувьд нэлээд хэмжээгээр буурсан байна. Харин уул уурхай болон дэд бүтцийн хөгжлийн нөлөөгөөр хүн ам шилжин ирснээр 2000-2010 онд Өмнөговь, Дорноговь аймгийн хүн ам өссөн байна (Зураг № 16). Тодруулбал сүүлийн нэг жилд Өмнөговь аймаг руу 8504 хүн шилжсэн нь Оюутолгой, Тавантолгой зэрэг уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж ажиллах хүч олноороо шилжин байршиж буйтай холбоотой юм<sup>2</sup>. (Хүн ам, орон сууцны тооллогын дүн, 2010).

<sup>2</sup> ҮСХ. 2011. Хүн ам, орон сууцны тооллогын дүн - 2010





Эх сурвалж: ҮСХ. Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2000, 2010 оны тооллогын дүн

Сүүлийн 10 жилд хүн амын шилжилт хөдөлгөөн илүү их эрчимжсэн байна (Зураг № 18). Улаанбаатар хотод шилжин ирэгсдийг насны бүтцээр авч үзвэл хөдөлмөрийн насны хүн ам дийлэнх хувийг эзлэж байгаагаас үзэхэд ерөнхийдөө ажлын байр хайж шилжин ирдэг гэсэн дүгнэлт хийж болно.


## **ГУРАВ. ХҮН АМЫН НУТАГШИЛТ, СУУРЬШЛЫН ХЭТИЙН ТӨЛӨВ, ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЦААШДЫН ХАНДЛАГА**

### **3.1. Хүн ам, хөдөлмөрийн нөөцийн өсөлтийн цаашдын чиг хандлага (2016-2030 оноор)**

Үндэсний статистикийн хороо, эрдэмтэд олон улсын аргачлалын дагуу гурван загвараар тооцоолсон Монгол улсын хүн амын 2008-2030 оны хэтийн тооцооны үр дүнгээс харахад хүн ам зүйн дараахь гол хандлага ажиглагдаж байна. Үүнд:

- Үндэсний статистикийн хорооны 3 хувилбараас хүн амын өсөлтийн 2010 оны үзүүлэлттэй тохирч буй 1А хувилбарын хэтийн тооцоогоор 2010 онд Монгол улсын хүн ам 2.754 сая, 2016 онд 3.030 сая, 2021 онд 3.224 сая, 2030 онд 3.556 сая болж өсөхөөр байна. Хүн амын жилийн дундаж өсөлт жилд дунджаар 1.27 хувь байх бөгөөд 2010 онд 1.5 хувь, 2030 онд 1.08 хувь болж буурахаар байна. Тодруулбал 2014 он хүртэл хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд тогтвортой байх боловч түүнээс цаашид нэлээд хурдацтай буурахаар байна. Энд төрөх насны хүн амын тоо цаашид буурахтай холбоотой юм.

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.




Эх сурвалж: ҮСХ. Монгол Улсын хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүн, 2011 он

ҮСХ. Монгол Улсын хүн амын 2008-2030 оны хэтийн тооцоо, 2008 он.

- Хүн амын нас-хүйсний бүтцэд нэлээд өөрчлөлт гарч, Монгол Улсын хүн ам идэрших хандлагатай байна. Тухайлбал, 2010 оны байдлаар 0-14 насны бүлгийн хүн ам нийт хүн амын 27.3 хувь, 14-64 насны бүлгийн хүн ам 68.9 хувь, 65 ба түүнээс дээш насны бүлгийн хүн ам 3.7 хувийг тус тус эзэлж байгаа бол 2030 онд 0-14 насны бүлгийн хүн ам 23.8 хувь хүртэл буурч, 65 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь 8.0 хувьд хүрч хоёр дахин өсөхөөр байна (Зураг 22).
- Хүн амзүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны (олон улсын жишгээр 15-64 насны хүн ам) 100 хүнд ногдох хүүхэд, ахмад настны тоо буурч байна. Нөгөө талаар ахмад настны хувийн жин 2020 оноос эрчимтэй нэмэгдэж байгаатай холбоотойгоор хөдөлмөрийн зах зээл, эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлж байсан “хүн амзүйн цонх” мөн оноос эхэлж хаагдахаар байна.

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.



Эх сурвалж: ҮСХ. Монгол Улсын хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого  
Монгол Улсын хүн амын 2008-2030 оны хэтийн тооцоо

### 3.3. Үйлдвэрлэлийн хөгжил, төвлөрөлтэй уялдсан хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэргэжилтэй ажиллах хүчний судалгаа

#### Монгол улсын хөдөлмөрийн зах зээлд нэмэгдэх ажиллах хүчний шинэ эх үүсвэр

Монгол улсын хөдөлмөрийн зах зээлд эрэлт үүсгэх ажиллах хүчний шинэ эх үүсвэрийг дараахь хоёр хэлбэрээр тооцож болох юм. Нэгдүгээрт, хөдөлмөрийн зах зээлд шилжих ерөнхий эх үүсвэр, хоёрдугаарт, шилжилт хөдөлгөөн болон хүн амын суурьшилтай уялдан бий болох ажиллах хүчний эрэлт гэсэн хоёр үзүүлэлтээр авч үзье.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд шинээр шилжин ирэх ажиллах хүчний эрэлтийг өнөөдөр бүх шатны сургалтын байгууллагад суралцаж буй суралцагчид болон хөдөлмөрийн насанд дэвших залуучуудаас ердийн хэвийн хорогдлыг тооцсон дундаж үзүүлэлтээр бодит хүн амд тулгуурлан тооцлоо.

Хүснэгт № 12

#### Хөдөлмөрийн зах зээлд шилжих хүний тооны төсөөлөл, мянган хүнээр

№	Үзүүлэлт	2010-2015	2015-2020
1.	Их, дээд сургууль, коллежийн төгсөгчид	207.8	200.0
2.	МСҮТ-ийн төгсөгчид	83.1	67.9
3.	Төрөл бүрийн дамжааны төгсөгчид	9.0	-
4.	Ерөнхий боловсролын сургууль төгсөгчид	9.0	-
5.	Бусад (цэргийн албанаас халагдах, шүүхийн шийдвэр биелүүлэх газраас суллагдах, гадаадаас буцаж ирэх г.м.)	30.0	35.0
6.	Хөдөлмөрийн байгууллагад бүртгэлтэй ажилгүйчүүд	38.3	-
7.	Хөдөлмөр эрхлээгүй иргэд	113.4	-
8.	Жирийн урсгал (шилжилт хөдөлгөөн)	52.1	-

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

Бүгд	542.3	302.9
------	-------	-------

Эх сурвалж: БСШУЯ. Боловсролын салбарын статистик мэдээлэл 2010,2011 он.  
ҮСХ. Хүн амын хэтийн төлөвийн тооцоо, 2008 он,  
НХХЯ-ны статистик мэдээлэл 2006-2010оны мэдээллэр тооцов./СБ/

Ойрын 5 жилд ажлын байр шаардах ажиллах хүчний нийлүүлэлтийн эх үүсвэрийг 2010-2015 онд бүх шатны сургууль төгсөх одоо суралцаж байгаа болон цаашид дэвшин суралцах, одоогоор ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хүүхэд залуучууд, өнөөдөр ажилгүй байгаа иргэд , цэргээс халагдах, хорихоос суллагдах иргэдийн дундаж тоо, ажиллагчдын урсгал шилжилт хөдөлгөөнөөр тооцоход бүрэн ажил эрхлэлтийг хангахад 542.3 мянган хүний ажлын байр шаарлагатай гэсэн тооцоо гарч байна. Энд орон тооны цомхотгол болон гэнэтийн ажилгүйдлийг зөвхөн олон жилийн дундаж ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнөөр тооцсон болно.

Харин 2015-2020 шинээр ажлын байр шаардах ажиллах хүчний нийлүүлэлтийн тооцоог тухайн онуудад ерөнхий боловсролын сургууль болон дараагийн шатны сургуульд дэвшин орж төгсөж хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэгдэх одоо ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа болон сургууль завсардсан боловч хөдөлмөрийн насанд дэвших залуучуудын тоонд үндэслэн тооцоход 2015-2020 онд хөдөлмөрийн зах зээлд 302.9 мянган ажиллах хүч нийлүүлэгдэх тооцоо гарч байна.

### **3.2.1. Уул уурхайн салбар**

Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын хөгжилтэй холбогдон тодорхой хэмжээний ажлын байр, суурьшил бий болж байгаа боловч тодорхой бодлого төлөвлөлт, суурьшлын ерөнхий төлөвлөгөөгүй, асуудлыг ажил олгогч буюу уул уурхайн байгууллагын эзний түвшинд шийдвэрлэх хэмжээнд орхигдуулж, энэ чиглэлийн төрийн бодлого үгүйлэгдэж байна.

Тухайлбал, Оюутолгой төслийн хүрээнд хотжилт суурьшлын тооцоогүй, одоогийн байдлаар ажиллагчдыг олон ээлжээр ажиллуулах, удаан хугацааны амралт өгөх замаар суурьшил буй болохоос зайлсхийсэн бодлого илт баримталж байгаа нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, үндэстэн дамжсан корпорациуд Ази, Африкийн буурай хөгжилтэй орнуудын байгалийн баялгийг орчин үеийн техник, технологийг ашиглаж, нутгийн хямд ажиллах хүчээр богино хугацаанд хамж аваад байгалийг сүйтгээд гардаг дахь гашуун туршлагыг бид сайн хэрэгжүүлж байна. Энэ талаар баримтлах төрийн бодлого, чиглэл, шаардлага ч тодорхойгүй байна.

Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээнд уурхайн үйлдвэрлэлийг түшиглэсэн хот байгуулах талаар огт тусгаагүй байна. Гэтэл Оюутолгойн уурхайн сууринд 15.0 мянган хүн ажиллаж амьдарч байгааг дундаж гэр бүлийн 4 хүнээр тооцоход дор хаяж 60.0 мянган хүн амтай хотыг даруй байгуулах шаардлагатай байна гэсэн үг юм. Суурингийн хүн ам уурхайн ажилчдын байранд амьдарсаар байгаа нь нийгэм, эдийн засгийн дараах сөрөг үр дагаварт хүргэдэг. Үүнд:

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

- Боловсрол, эрүүл мэнд болон бусад соёлын үйлчилгээнээс алсгагдаж, тэдгээр үйлчилгээг зохих түвшинд хүртэж чадахгүй байна.
- Ажиллагсад нь гэр бүлээсээ удаан хугацаанд тусдаа амьдарснаар гэр бүлээ санах, ажлаа өөрчлөх, гэр бүлийн тогтвортой байдал алдагдах, гэр бүл салалт нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар гардаг.
- Ажиллагсдын сар бүр гэртээ ирж очих тээврийн зардал өндөр байгаа нь гэр бүлийн эдийн засгийн зардлыг ихэсгэж байна.

Хүн ам, зах зээлийн төвлөрөл бүхий уурхайн үйлдвэрлэл түшиглэсэн хот байгуулснаар түүнийг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжиж, нутгийн эдийн засаг, орлогыг нэмэгдүүлэх боломж бүрдэхээс гадна бусад бүс нутгаас ажиллах хүч түр хугацаагаар татаж хөдөлмөрийн зах зээлийн тогтвортой байдлыг алдагдуулах явдал багасна. Нөгөө талаар ерөнхий төлөвлөгөөгүй, эмх замбараагүй суурьшлын бүс байгуулагдахаас сэргийлж, хүн амын хөгжлийн асуудлыг бодлогын хүрээнд шийдвэрлэх хот төлөвлөлтийн бодлого хэрэгжих боломжийг бүрдүүлэх юм.

Хүснэгт № 14

**Ойрын жилүүдэд ашиглалтанд орох уул уурхайн орд,  
түүнийг дагасан үйлдвэрүүд**

№	Уул уурхайн орд, үйлдвэрийн нэр	Аймаг, сумын нэр	Эхний ээлжинд бий болох ажлын байр ажиллагчид	Ажилчдын гэр бүлийн гишүүд	Хамааралтай иргэд	Нийт хүн ам
1.	Баянголын төмрийн хүдрийн уурхай	Сэлэнгэ, Ерөө	350	1085	1435	2870
2.	Таян нүүрсний уурхай	Говь-Алтай, Цээл	600	1860	2460	4920
3.	Зүүн төмөртэйн цайр, төмрийн баяжуулах үйлдвэр	Дундговь, Говь- Угтаал	120	372	492	984
4.	Цагаан дэлийн жоншны уурхай	Дорноговь, Айраг	30	93	123	246
5.	Дайрганы үйлдвэр	Төв, Алтанбулаг	20	62	82	164
6.	Чулуутын зүүн салааны жоншны уурхай	Төв, Баянцагаан	30	93	123	246
7.	Бумбатын жоншны үйлдвэр	Дундговь, Говь- Угтаал	30	93	123	246
8.	Оюут овоогын төмрийн хүдрийн ил уурхай	Дундговь, Эрдэнэ	80	248	328	656
9.	Төмрийн хүдрийн уурхай	Хэнтий, Дархан	50	155	205	410
10.	Тогоотын хөндийн алтны уурхай	Дорнод, Баян-Уул	30	93	123	246
11.	Бухт-Уул алтны уурхай	Сүхбаатар	80	248	328	656
12.	Цахиуртын овооны төмрийн хүдрийн уурхай	Сүхбаатар, Уулбаян	150	465	615	1230
13.	Баруун нарангийн нүүрсний ил уурхай	Өмнөговь, Ханхонгор	220	682	902	1804

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

14.	Тоосгоны шаврын ил уурхай	Улаанбаатар, Налайх	25	77.5	102	204.5
15.	Хөшөөтийн нүүрсний ил уурхай	Ховд, Цэцэг	450	1395	1845	3690
16.	Оюутолгой	Өмнөговь, Ханбогд	12317	37232	49049	98498
17.	Эрдэнэс таван толгой	Өмнөговь, Цогтцэций	630	1953	2583	5166
18.	Таван толгойн дагалдах барилга, байгууламж дээр бий болох ажлын байр /нүүрс угаах үйлдвэр, цахилгаан станц, зам г.м/	Өмнөговь, Цогтцэций	5600	17360	22960	45920
19.	Улаан Овоо		60	168	246	474
20.	Энержи ресурси	Өмнөговь, Цогтцэций	770	2387	3157	6314
21.	Хөшөөт	Ховд	675	2092	2767	5534
22.	Шинээр байгуулагдах хагас коксон түлшний үйлдвэр	Улаанбаатар	140	434	574	1148
23.	Шинээр байгуулагдах хагас коксон түлшний үйлдвэр	Дархан-Уул, Шарын гол	65	201.5	266	532
24.	Шинээр байгуулагдах хагас коксон түлшний үйлдвэр	Төв, Баян	20	68	82	170
25.	Газрын тос боловсруулах үйлдвэр	Дархан-Уул	600	1860	2460	4920
26.	Газрын тос боловсруулах үйлдвэр	Дорноговь	100	310	410	820
27.	Газрын тос боловсруулах үйлдвэр	Дорнод	120	372	492	984
БҮГД			<b>28862</b>	<b>89472</b>	<b>118334</b>	<b>236668</b>

Эх сурвалж: “Таван Толгой, Оюу Толгой болон Цагаан Суваргын ордод тулгуурласан орон нутгийн хөгжил болон хот байгуулалтын төлөвлөгөө”, ЗТБХБЯ,ЭБЭХЯ,ҮХШХ-ны тайлан, мэдээ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн төлөвлөгөө, тайлан, мэдээ болон Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын мэдээнд суурилан тооцов (ҮХХ-ийн судалгааны баг), 2011 он.

Дээрхи судалгаанаас харахад, уул уурхайн салбарт шинээр байгуулагдах уурхай, үйлдвэр, аж ахуйн газарт 28862 ажлын байр шинээр бий болж, түүнийг дагасан хот суурин газруудад ойрын ирээдүйд 236.6 мянган хүний нутагшил суурьшил бий болох таамаг дэвшүүлж байна.

### 3.2.2. Дэд бүтцийн салбар.

Монгол Улсын Мянганы зам төсөл, “Төмөр замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлого” зэрэг бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зам тээврийн салбарт бодитой ахиц дэвшил гарч улсын эдийн засагт онцгой үүрэг гүйцэтгэж байна. Өргөн уудам нутагтай, хүн ам харьцангуй сийрэг суурьшилтай манай орны хувьд зам, тээврийн салбар чухал ач холбогдолтой салбарын нэг юм. Сүүлийн 4 жилийн статистик мэдээллээс харахад тээврийн салбарын ачаа эргэлт 9030.2 сая т.км-ээс 12124.8 сая т.км буюу 30.0-аад хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтийг дагаж ажиллах хүчний тоо ч өсчээ.

**Дэд бүтцийн салбарт шинээр бий болох ажлын байрны тооцоо**

№	Салбар, ажлын чиглэл	Шинээр бий болох ажлын байр	Үүнээс	
			Бүтээн байгуулалтын үеийн	Байнгын
<b>1.</b>	<b>Барилгын салбарт</b>	<b>54695</b>	<b>21878</b>	<b>32817</b>
Үүнээс:	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэргжүүлэхэд шаардагдах	19924	7970	11954
	“100 мянган орон сууц “ хөтөлбөр хэрэгжүүлэхэд	34771	13908	20863
<b>2.</b>	<b>Төмөр замын салбарт</b>	<b>3823</b>	<b>2929</b>	<b>894</b>
Үүнээс:	Замын доод бүтэц буюу далангийн ажил	1325	1325	-
	Замын дээд бүтцийн угсралт болон замын үе тавих ажил	760	760	-
	Дохиолол, төвлөрүүлэлт хориглол, холбооны угсралтын ажил	52	52	-
	Буталмал чулуу бэлтгэх үйлдвэр	522	522	-
	Төмөр бетонон дэрний үйлдвэр	270	270	-
	Төмөр замын засвар үйлчилгээ, ашиглалт /Нарийн сухайт -Шивээ хүрэн, Ухаа худаг - Оюутолгой -Гашуун сухайт, Таван толгой-Цагаан суврага -Сайншанд, Сайншанд-Чойбалсан, /	894	-	894
<b>3.</b>	<b>Авто замын салбарт</b>	<b>3724</b>	<b>3424</b>	<b>300**</b>
Үүнээс:	Гадаадын зээл тусламжаар баригдаж буй төсөл	846	846	-
	“Мянганы зам” төсөл	850	850	-
	Аймгийн төвүүдийг улаанбаатартай холбох зам	615	615	-
	“Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөр”	364	364	-
	Аялал жуулчлалын зам	549	549	-
	Авто замын засвар үйлчилгээнд	300	-	300**
<b>4.</b>	<b>Тээврийн салбар</b>	<b>5800</b>		<b>5800</b>
Үүнээс:	Уул уурхайн ачаа тээвэрлэлтэнд	5000		5000
	Хот, суурин газрын нийтийн үйлчилгээнд	600		600
	Хот хоорондын үйлчилгээнд	200		200
<b>5.</b>	<b>Иргэний нисэхийн салбарт</b>	<b>2175</b>	<b>124</b>	<b>2051</b>
Үүнээс:	Аймгуудын нисэх буудлын үйлчилгээнд	156	124	32
	Хөшигтийн хөндийн шинэ нисэх буудал	2000	-	2000
	Бусад	19	-	19
<b>6.</b>	<b>Эрчим хүчний салбарт</b>	<b>4100</b>		<b>4100</b>
Үүнээс:	Таван толгой цахилгаан станц	840	-	840
	Шивээ овоогийн цахилгаан станц	2000	-	2000

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

ДЦС-5	1300	-	1300
Эрчим хүчний дэд бүтэц, түгээлт, ашиглалт	**	**	**
<b>Дэд бүтцийн салбар, бүгд</b>	<b>74317</b>	<b>28355</b>	<b>45962</b>

Эх үүсвэр: ТЭЗҮ болон ЗТХБЯ,ЭБЭХЯ-ны мэдээ тайлан 2010, АДВ-ны Судалгааны тайлан-2009 үндэслэн тооцов.

Дэд бүтцийн салбарт нийт 22944 ажлын байр шинээр нэмэгдэх төлөвтэй байна. Үүнээс төмөр замын салбарт 2459 ажлын байр, барилгын салбарт – 13500, автозамын салбарт – 3224, автотээврийн салбарт – 3403, иргэний нисэхийн салбарт 358 ажлын байр тус тус нэмэгдэхээр байна.

Шинэ төмөр зам бүтээн байгуулалтаар эхний шатанд баригдах Даланзадгад-Чойбалсангийн чиглэлийн төмөр замын суурь бүтцийг тавих ажил үндсэндээ эхэлсэн байна. Энэ бүтээн байгуулалтын ажлын хүрээнд зам барих ажилд 2450 ажлын байр шаардлагатай байгаагийн дээр баригдаж дууссаны дараа энэхүү дэд бүтцийг дагасан үйлчилгээ, тээврийн хэрэгслийн засвар, төмөр замын зангилаанд 500–аад тогтмол ажлын байр эхний шатанд гарахаар тооцогдсон байна. Аймгийн төвүүдийг Улаанбаатар хоттой холбох хатуу хучилттай авто зам, аялал жуулчлалын замууд, мянганы замын үргэлжлэл зэрэг зам, гүүр барьж байгуулах ажилд 2011 онд 3200 ажилчин шаардлагатай, цаашид ч энэ чиглэлийн ажлын байрны тоо нэмэгдэх хандлагатай байна. Сүүлийн жилүүдэд авто тээврийн салбарт ажиллагчдын тоо тогтмол өсөх хандлагатай байна. Энэ нь уул уурхай салбарын бүтээгдэхүүн тээвэрлэх, барилга бүтээн байгуулалтын салбарын тээврийн ажил үйлчилгээ, хотын доторх такси болон хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ нэмэгдэж байгаатай шууд холбоотой ажээ.

Иргэний нисэхийн салбарт ч олон ажлын байр шинээр гарах төлөвтэй байна. Иргэний нисэхийн компаниудын улс, хот хоорондын ачаа тээврийн урсгал нэмэгдэж байгаатай холбогдон онгоцны тоо, байнгын ажиллагаатай онгоцны буудлын тоо, тэнд ажиллагчдын тоо өсөж байгаагийн дээр шинээр баригдах Олон улсын онгоцны буудлыг дагаж олон ажлын байр гарах төлөвтэй байна. Энэ салбарын ажиллах хүчний тооцоогоор 2011 онд 22900 ажлын байр гарах тооцоо гаргасны дээр цаашид ч авто болон төмөр зам , агаарын тээврийн үйлчилгээ даган хүн амын суурьшил тодорхой газруудад гарахаар төлөвлөгдөж байна.

### **3.2.3. Хүн амын нутагшил, суурьшил нэмэгдэх хот суурин газруудад шинээр бий болох ажлын байрны тооцоо.**

Монгол улсын эдийн засгийн өсөлтийг дагасан үйлдвэржилт, хүн ам ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, суурьшилттай холбогдон зарим газар шинэ хот суурин байгуулагдах, татах хүч өндөр бүсийн болон эдийн засгийн тулгуур төвүүдэд шинэ ажлын байрууд олноор бий болж түүнийг даган нийтлэг үйлчилгээний / засаг захиргаа, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, тээвэр, худалдаа, нийтийн хоол г.м / салбарын хүрээ өргөжих юм. Дээрхи тооцоог хүн амын нийт өсөлттэй холбон



Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

тооцсон бол энд суурьшлын төвүүдээр тооцож байгаа нь тухайн суурьшлын төвийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн хөрөнгө оруулалтын тооцоо хийхэд үр дүнтэй юм. Эдгээр төвүүдийн суурьшлын төлөвлөгөөг дээрх ерөнхий тооцоо хийсэн “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”-ийн дагуу тооцож нэгдсэн дүнг гаргалаа. Суурьшлын төв бүрээр хийсэн тооцоог хавсралтаас харна уу.

**Хүн амын суурьшил нэмэгдэх газруудын нийгмийн үйлчилгээнд шаардлагатай ажлын байрны тооцоо./ 2010-2015 онд/**

№	Хот сумын нэр	Шинээр нэмэгдэх хүн амын тоо	Шинээр бий болох ажлын байрны тоо	Төлөв лөсөн он
1	Нисэхийн хотхон	150000	6890	2015-2020
2	Мэдээлэл, технологийн парк, оюуны хотхон /Байршил Налайх, Төв аймаг, Шивээтийн хөндий/	150000	6890	2015-2020
3	Тавантолгой, Оюутолгойн уурхайг түшиглэсэн говийн бүсийн хот	Цогтцэций	1308	2015
		Ханбогд	1546	2015
4	Дархан 74985*-80380**-85775***	10780	475	2015
5	Арвайхээр 27178*-29132**-31086***	3908	166	2015
6	Улиастай 17485*-18741**-19997***	2512	118	2015
5	Сайншанд 20643*-22128**-23619***	2976	119	2015
6	Ховд 29046*-31134**-33222***	4176	178	2015
7	Чойбалсан 38615*-41392**-44169***	5554	240	2015
8	Даланзадгад 18781*-20130**-21479***	2698	118	2015
9	Замын-Үүд 13289*-14243**-15197***	1908	83	2015
10	Дорнын “ Наран “ эдийн засгийн чөлөөт бүс / Орос, Монгол, Хятад гурван улсын хамтарсан дундын чөлөөт бүс/ Нийт 450000 хүн амаас Монгол 150000.	150000	6423	2020****
11	Хилийн боомтууд / Цагааннуур, Алтанбулаг, Эрээнцав, Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн, Ярант /	10000	428	2015
	<b>БҮГД</b>	559512	24982	-

\*Хүн амын тоо 2010 оны тооллогоор, \*\*Хүн амын тоо ердийн өсөлтөөр 2015 оны түвшинд, \*\*\*Хүн амын тоо нутагшил, суурьшил, хөрөнгө оруулалтын бодлогоор нэмэгдэх. \*\*\*\*2020 оны түвшинд

Дээрхи судалгаанаас харахад хүн амын суурьшил нэмэгдэх эдгээр газруудын нийтлэг үйлчилгээний салбарт 24982 ажлын байр шинээр бий болох тооцоо гарч байна. Нөгөө талаар хүн амын нийт өсөлттэй уялдуулан хийсэн тооцооноос ажлын

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

байрны тоо өндөр гарч байгаа нь үйлчилгээний ажлын байр хүн амын байршил, тархалттай холбоотой нэмэгддэгтэй нийцэж байна.

### 3.2.4. Ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн нэгдсэн тойм

Судалгааг хийхдээ энэ чиглэлээр хийгдсэн судалгааны материал болон хүн ам ажиллах хүчний судалгаа хийх нэгдсэн аргачлал, хот байгуулалт, суурьшилтын норм, нормативууд болон ажиллах хүчний эрэлтийг салбарын хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт ашиглан тооцох олон улсын аргачлалын дагуу судалж тооцож үзлээ. Бидний хийсэн судалгааны хүрээнд 2010-2015 онд Монгол улсын хүн ам 276.1 мянган хүнээр өсөхийн зэрэгцээ их дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль төгсөж шинээр хөдөлмөрийн зах зээлд 299.9 мянган залуучууд шилжих бөгөөд хөдөлмөрийн зах зээлд тойм судалгаагаар 199.6 мянган шинэ ажлын байр бий болох тооцоо гарч байна.

Хүснэгт №19

#### Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвтэй уялдан шинээр бий болох ажиллах хүчний нэгдсэн эрэлт

№	Ажиллах хүчний эрэлт салбараар	2010-2015
1	Уул уурхайн салбар	28,862.0
2	Дэд бүтцийн салбар	74,317.0
	Үүнээс: Барилга	54,695.0
	Төмөр зам	3,823.0
	Автозам	3,724.0
	Иргэний нисэх	2,175.0
	Тээвэр	5,800.0
	Эрчим хүч	4,100.
3	Боловсруулах аж үйлдвэрийн салбар	12,024.0*
4.	Хөдөө аж ахуйн салбар	43,400.0
	Үүнээс: Мал аж ахуй	32000.0
	Газар тариалан	11400.0
5.	Нийтлэг үйлчилгээний салбар “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”-ийн дагуу тооцоолсон дүн	24,982.0**
6.	Хот байгуулалтын салбар /оюутны хотхон, хөшигийн хөндий, шинэ орон сууцны хорооллууд/	13,000.0
	<b>БҮГД</b>	<b>196,585.0</b>

Эх сурвалж: ҮСХ-ны салбарын мэдээлэл.2000-2010, ЗТХБЯ,ЭБЭХЯ,ХХААХҮЯ-ны тайлан, мэдээлэлд үндэслэн тооцов.Судалгааны баг. /\*/ ADB-ийн хөдөлмөрийн бүтээмжээр тооцсон тооцоо, /\*\*/-хотжилтын нормативаар суурьшлын төвүүдээр хийсэн тооцоогоор/СБ/

### 3.3. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн төвүүдийн хэтийн төлөв

#### 3.3.1. Хэт төвлөрлийг сааруулж, шинэ хотжилтыг үүсгэн “Нисэхийн хотхон”-ыг төлөвлөн хөгжүүлэх

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

**Нийслэл Улаанбаатар хотын хүн ам, нийгэм-эдийн засгийн хэт төвлөрлийг сааруулах:** Дэлхийн улс орнуудын нийслэлд хүн амын хэт төвлөрлөөс үүдэлтэй хүрээлэн буй орчны бохирдлын асуудал нь дэлхийн олон оронд тулгарсаар ирсэн бөгөөд үүнийг нийслэлээ нүүлгэн шилжүүлэх, эсвэл 2 дахь нийслэл хотыг бий болгох, нийслэлийн дэргэд шинэ дагуул хот байгуулах, дагуул хотыг өргөжүүлэх замаар хүн амын хэт төвлөрлийг сааруулж, тогтвортой хөгжил бүхий хүн амын суурьшлын бодлогыг хэрэгжүүлж ирсэн.

Сүүлийн 20 жилийн хүн амын жилийн дундаж өсөлтийн 4.4 хувиар ирээдүйн хүн амын өсөлтийн загварыг гарган үзэхэд одоогийн хүн амын өсөлтийн эрчмээр явбал нийслэлийн хүн ам 2016 онд 1.5 сая, 2023 онд 2.0 саяд хүрч өсөх төлөвтэй байна (Зураг № 24). Иймд нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулах үүднээс дагуул хот бусад аймаг, орон нутагт хүн амыг тогтвортой суурьших нөхцлийг хангах талаар яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байна.

### **Хөшигийн хөндийд Нисэхийн хотхон (Airport city) хөгжүүлэх**

Үндэсний болон улс хоорондын тээврийн сүлжээнд нисэх буудал чухал үүрэгтэй бөгөөд дэлхийн даяаршил, бүс нутгийн эрчимтэй хөгжлийг дагаж түүний үүрэг, ач холбогдол улам нэмэгдэж байна. Тив, бүс нутагт бизнесийг татан хөгжүүлэхэд агаарын тээвэр нисэх буудлын үйлчилгээ бий болгох нь шинэ хот байгуулалтын энэ тэргүүнд шийдвэрлэвэл зохих асуудлын нэг билээ. Нисэх буудал, агаарын тээврийн хүртээмжтэй шуурхай үйлчилгээнд тулгуурлаж, худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах практик олон улсад дэлгэрсэн<sup>3</sup>. Жишээлбэл, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, бизнесийн таатай орчин бүрдүүлэх, нисэх буудлын дэд бүтцийг ашиглан тээврийн цогц сүлжээг бий болгох замаар чөлөөт худалдааг хөгжүүлэх, олон улсын ложистикийн сүлжээ тогтолцоонд нэгдэх зорилгоор БНСУ-ын Инчеон нисэх буудлын орчим хүн амын төвлөрөл, хот байгуулалтын шинэ төв бүхий эдийн засгийн чөлөөт бүс бий болгох арга хэмжээг хэрэгжүүлж байгаа нь үүний нэг тод жишээ юм.

### **Зураг № 25. Нисэхийн хотхон (Airport city, aerotropolis) хөгжлийн загвар**

---

<sup>3</sup> Хот байгуулалт ТӨҮГ. Эртний нийслэл Хархорумыг жишиг хот болгон хөгжүүлэх хөтөлбөрийн төсөл, 2005.

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

**Онгоцны буудлын  
цогцолбор**

**Онгоцны буудлын  
гаднах хот**

Нэмүү өртөгт бүтээгдэхүүн, үйлчилгээ

Хэрэглэгч, захиалагчдад  
үйлчлэх

Худалдааны танхимууд

Оффис, зочид буудал  
карго

Такси, автобус, метро

Терминал

Нислэгийн  
зурвас зам

Нэмэлт зорчигч, ачаа

Түрээсийн байр,  
зочид буудал, орон сууц  
Байр

Хурал, ҮЗЭС

Үзвэр үйлчилгээ

Жижиглэн  
худалдаа

Оффис, бизнесийн  
үйлчилгээ, үйлдвэр

Тээвэр, ложистик

Бараа, бүтээгдэхүүн  
үйлдвэрлэл

Хурал, Үзэсгэлэн

Ресторан, клуб,  
чөлөөт цаг

Худалдааны төвүүд

Кластер бизнес  
паркууд

Ачаа тээвэр

Аж үйлдвэрийн  
паркууд

Эх сурвалж: "Global airport cities" magazine, 2010

Нисэх буудал болон түүнийг дагасан хот нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд эд баялаг, ажлын байрыг бий болгож, хөгжиж буй харилцан уялдаа холбоотой зах зээлүүдийн хооронд өндөр хурдтай харилцаа, холбоог бүрдүүлдэг (Зураг 25).

**Хүснэгт № 20**

**Хөшигтийн хөндийн нисэх буудлын хотхоны төлөвлөлт**

№	Үзүүлэлтүүд	Баримтууд
1.	<b>Байршил</b>	Улаанбаатар хотоос баруун урд зүг 54 км-т, Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг Хөшигтийн хөндийд дэргэдэх Шивээтийн хөндийн 2000 га газар Хөшигтийн хөндий нь хоосон задгай тал тул нислэгийн аюулгүй байдал, цаашдын хотхоны хөгжлийн төлөвлөлт хийхэд нэн тохиромжтой.
2.	<b>Онгоцны буудлын цогцолборт ажиллагчдын тоо</b>	5 авиа компанийн нийт 3500 ажиллагчид
3.	<b>Нисэхийн хотхоны бусад ажиллагчдын тоо</b>	Дэд, бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээний нийт 4000 ажилчид
4.	<b>Нисэхийн хотхоны нийт хүн амын тоо</b>	2021 он гэхэд 150 мянган хүнтэй байх
	<b>Хүчин чадал</b>	2016 онд 1.5 сая зорчигчийг хүлээж авах бөгөөд
5.	<b>Төсөв</b>	300 сая ам.доллар + суурь дэд бүтэц + хотхоны хөгжлийн бүтээн байгуулалт
	<b>Санхүүгийн эх үүсвэр</b>	<ul style="list-style-type: none"> <li>Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл 300 сая ам.доллар</li> </ul>

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

		<ul style="list-style-type: none"> <li>Суурь дэд бүтцийн хөрөнгө оруулалт – улсын төсвөөс</li> </ul>
	<b>Дэд бүтэц</b>	<ul style="list-style-type: none"> <li>Хурдны авто зам</li> <li>Цахилгааны болон дулааны инженерийн шугам сүлжээ</li> </ul>
	<b>Талуудын үүрэг</b>	<ul style="list-style-type: none"> <li>Онгоцны буудлыг Японы техник, технологиор барьж, шаардагдах тодорхой бараа материалыг Японы тал нийлүүлнэ.</li> <li>Японы тал барилгын зураг төслийг зохиож, барилгын ажлыг удирдан, ерөнхий хяналт тавина.</li> <li>Монголын тал шинэ онгоцны буудлыг дэд бүтцээр хангах үүрэг хүлээсэн.</li> </ul>
	<b>Хугацаа</b>	2012 – 2015 онд барьж, ашиглалтад хүлээлгэн өгнө.
6.	<b>Явц</b>	Нисэх буудлын цогцолборын ерөнхий төлөвлөгөө батлагдсан. 2015 онд ашиглалтад оруулж, үйл ажиллагаагаа нээхээр төлөвлөгдсөн.

Нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулах үүднээс олон улсын нисэх буудал, мэдээлэл технологийн төв бүхий 2021 он гэхэд 150.0 мянган хүн амтай шинэ хотыг нийслэлээс баруун урд зүгт 50.0 км орчим зайд байрлах Хөшгийн хөндийн олон улсын нисэх буудлыг түшиглэн байгуулах шаардлагатай юм.

### 3.3.2. Мэдээлэл, технологийн парк, оюуны хотхон

Нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулж, хүрээлэн буй орчны бохирдлыг багасгах, мөн олон улсын жишигт нийцсэн дээд боловсролын үйлчилгээг нэвтрүүлэх үүднээс Налайхын Шивээтийн хөндий, Төв аймгийн Зуун мод хот, Налайх хотод Оюуны хотхоныг төвлөрүүлэн байгуулах бололцоотой гэж судалгааны багаас санал дэвшүүлж байна.

#### Хүснэгт № 21

#### Шивээтийн хөндийн мэдээлэл, технологийн парк – оюуны хотхоны төлөвлөлт<sup>4</sup>

№	Үндсэн үзүүлэлт	Баримтууд
1.	<b>Байршил</b>	Улаанбаатар хотоос зүүн зүг 40.0 км-т Налайхын дэргэдэх Шивээтийн хөндийн 2000.0 га газар
2.	<b>Оюутны тоо</b>	5 их сургуулийн 81,600 оюутан
3.	<b>Багш, ажилчдын тоо</b>	5 их сургуулийн 5,820 багш, ажилчид ШУА-ийн 6 хүрээлэнгийн 330 эрдэмтэн
4.	<b>Нийт хүн ам</b>	150.0 мянган хүн
5.	<b>Төсөв</b>	400.0-500.0 сая ам.доллар
6.	<b>Санхүүгийн эх үүсвэр</b>	Хотын төвийн сургуулиудын хуучин байрыг зарах Хөнгөлөлттэй зээл Олон улсын тусламж, хандив Их сургуулиудын үйл ажиллагааны ашгаас

<sup>4</sup> БСШУЯ. 2011. Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

		Улсын төсвийн хөрөнгө
7.	<b>Дэд бүтэц</b>	100 мегабайтын Дулааны цахилгаан станцыг БНСУ-ын “Косеф” компани барина. Цэвэрлэх байгууламж Нэгдсэн номын санг БНСУ-ын тусламжаар барина. 100.0 мянган оюутны хичээлийн байр, дотуур байр 6000 багш ажилчдын орон сууц Үйлдвэр, үйлчилгээний барилга
8.	<b>Явц</b>	Оюутны хотхоны ерөнхий төлөвлөгөө батлагдсан. 2012 онд барилгын ажлыг эхлүүлэхээр Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа төлөвлөсөн.

Оюутны хотхон байгуулах ажил зөвхөн Шивээтийн хөндий дэх бүтээн байгуулалтын ажлаар хязгаарлахгүй бөгөөд Зүүн бүсийн оюутны хотхон Дорнод аймагт, баруун бүсийнхийг Ховд аймагт байгуулахаар төлөвлөжээ. Түүнчлэн уул уурхайн чиглэлийн их сургуулийг Орхон аймагт, техник технологийн чиглэлийнхийг Дархан-Уул аймагт байгуулахаар төлөвлөгдсөн.

### 3.3.3. Уул уурхайн үйлдвэрлэл дагасан хүн амын суурьшлын төвүүд

Говийн бүс дэх уул уурхайн салбарын хөгжил нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлэн, шинэ суурьшлыг бий болгон, аймаг, сумын хүн амын тоо, тархалтын өөрчлөлтөд ихээхэн нөлөө үзүүлж байна.

**Зураг № 26. Уул уурхайн салбарт ажиллагсдын тоо, 2004-2010**



Эх сурвалж: ЭБЭХЯ. Уул уурхайн салбарын хөдөлмөр эрхлэлтийн төлөв, цаашдын хандлага, 2011 он.

Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж үүнийг дагаад хөдөлмөрийн насны хүн амыг ажлын байраар хангах томоохон салбарын нэг болж байна. Тодруулбал 2004 онд энэ салбарт 33,500 хүн ажиллаж байсан бол 2010 онд 48,100 болж 43.6 хувиар өссөн байна.

### Говийн бүсийн хүн амын одоогийн байдал болон хэтийн тооцоо

Аймаг, орд газрын нэр	2007		2010		2015		2021	
	Хүн амын тоо	Эзлэх хувь, %	Хүн амын тоо	Эзлэх хувь, %	Хүн амын тоо	Эзлэх хувь, %	Хүн амын тоо	Эзлэх хувь, %
<b>Говьсүмбэр</b>	12,600	7.7	13,240	7.2	18,000	6.5	25,000	5.9
• Чойр	9,700	5.9	10,697	5.8	14,000	5.0	18,000	4.3
<b>Дорноговь</b>	55,600	33.9	58,612	31.8	72,000	25.9	122,000	28.8
• Сайншанд	19,700	12.0	21,100	11.5	23,000	8.3	38,000	9.0
• Цагаан суварга	....		...		8,000	2.9	15,000	3.5
<b>Дундговь</b>	48,800	29.8	38,821	21.1	44,000	15.9	65,000	15.4
• Мандалговь	13,700	8.4	13,664	7.4	16,000	5.8	18,000	4.3
<b>Өмнөговь</b>	46,900	28.6	61,314	33.3	93,000	33.5	143,000	33.8
• Даланзадгад	15,200	9.3	18,781	10.2	22,000	7.9	29,000	6.9
• Оюутолгой	...		10,701	5.8	30,000	10.8	38,000	9.0
• Тавантолгой	...		1,500	0.8	12,500	4.5	15,000	3.5
<b>Нийт дүн</b>	<b>163,900</b>	100.0	<b>184,188</b>	100.0	<b>277,500</b>	100.0	<b>423,000</b>	100.0

Эх сурвалж: “Таван Толгой, Оюу Толгой болон Цагаан Суваргын ордод тулгуурласан орон нутгийн хөгжил болон хот байгуулалтын төлөвлөгөө”, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам, 2008 оны мэдээ болон Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын мэдээнд суурилав.

Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамнаас 2008 онд говийн дөрвөн аймгийн гол хотуудын хүн амын өсөлтийн таамгийг гаргажээ<sup>5</sup>. Энэхүү таамгаас үзэхэд, говийн дөрвөн аймгийн хүн ам 2021 он гэхэд 2.5 дахин нэмэгдэх ажээ. Эдгээр аймгаас Өмнөговь аймгийн хүн ам 2.5 дахин нэмэгдэх таамаглалтай буй нь говийн нийт аймгийн хүн амын дунд эзлэх хэмжээг 33.3%-иас 45.0% хүртэл өсгөх ажээ. Бусад аймагт 1.9-2.2 дахин өсөлттэй байхаар тооцжээ.

#### 3.3.4. Уул уурхай дагасан хотжилт

**Олон Улсын туршлага:** Дэлхийн уул уурхайн нийслэл хот – **Антофагаста, Чили:** Зэсийн уул уурхайн үйлдвэрлэл дагасан Антофагаста хот нь нийслэл Сантьяго хотоос хойд зүгт 1130 км зайд оршдог бөгөөд 2009 оны тооллогоор 360.0 мянган хүн амтай томоохон хот юм. Тус хот нь дэлхийд томоохонд орох тус улсын хамгийн том зэсийн уурхайг дагаж байрладаг. 1990 он гарснаар барилга, аж үйлдвэр, зочид буудал, агаарын тээврийн төв болон хөгжиж, хүн ам нь ихээр өсч буй хот юм. Тус хот Чилийн хотжилт болон эдийн засгийн хөгжилд хамгийн хурдацтай өсөн нэмэгдэж буй бүс нутаг болсон бөгөөд аж үйлдвэрийн 2 бүстэй бөгөөд нэг нь тус хотоос 20 км зайд байрлах зэсийн хүдэр боловсруулах, зэсийн цэвэршүүлсэн баяжмалын үйлдвэр, түүнчлэн шохойн чулуу бусад бүтээгдэхүүний үйлдвэрүүд байршсан. Мөн олон улсын уул уурхайн үзэсгэлэн, арга хэмжээ тогтмол

<sup>5</sup> ЗТБХБЯ, Таван Толгой, Оюу Толгой болон Цагаан Суваргын ордод тулгуурласан орон нутгийн хөгжил болон хот байгуулалтын төлөвлөгөө, 2008

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

явагддаг. Мөн тус хот Өмнөд Америкийн гадаадын хөрөнгө оруулалтыг хамгийн ихээр татсан хотын нэг юм.

Дээрх гадаад орны туршлагаас үзэхэд, Оюутолгой, Тавантолгойн уурхайг дагаж, 2 суманд 2011 оны 8 дугаар сарын байдлаар 18.0 мянга орчим хүн амын төвлөрөл бий болсныг харгалзан Засгийн газар Оюутолгой, Тавантолгой төсөлтэй хамтран Ханбогд эсвэл Цогтцэцийн сумын нутагт 2021 он гэхэд 85.0 мянган хүн амтай орчин үеийн хоёрдахь Эрдэнэт хот (Хүснэгт № 21) байгуулан хөгжүүлэх нь өнөөгийн төр, засгийн нэн тэргүүний зорилт байх учиртай. Дээрх хоёр уурхайд ажиллах ажилтан, ажилчид, тэдгээрийн гэр бүлийн ажиллаж амьдрах эрүүл, аюулгүй, тав тухтай орчин бий болсноор Үндсэн хуульд заасан үүргээ Засгийн газар биелүүлнэ, мөн байгалийн баялгийг ашиглаж дууссаны дараа эдгээр хот нь Эрдэнэт, Багануур хот шиг бүсийн төв болон хөгжих боломжтой болно.

Хүснэгт № 24

**Оюутолгой, Тавантолгойн уурхайг дагасан хүн амын төвлөрөл**

Уурхай	2011 он	2016 он - Олборлолт жигдрэх үе							2021 он	2030 он	
	Бэлтгэл үе	Уурхай	Дэд бүтэц			Нийт ажиллагчид	Гэр бүлийн хүмүүс	Бусад дагалдах салбарын хүн ам	Нийт хүн ам		
	Нийт ажиллагчид		Авто зам, төмөр зам	Цахилгаан, усны байгууламж	Авто тээвэр						
<b>Оюутолгой</b>	12,317	7,000	1,000	500	100	8,600	26,660	17,200	52,460	56,236	63,732
<b>Тавантолгой</b>	5,600	1,000	1,500	400	1,200	4,100	12,710	8,200	25,010	26,810	30,384
<b>Бүгд</b>	<b>17,917</b>	<b>8,000</b>	<b>2,500</b>	<b>900</b>	<b>1,300</b>	<b>12,700</b>	<b>39,370</b>	<b>25,400</b>	<b>77,470</b>	<b>83,046</b>	<b>94,116</b>

Эх сурвалж: 2011 оны уурхайнуудын ажиллагсдын мэдээг Оюутолгой ХХК-ын сар тутмын мэдээ болон ЭБЭХЯ-ны мэдээнээс авсан.



## **ДӨРӨВ. БОДЛОГЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

### **4.1. Судалгааны дүгнэлт**

Цаашдын үйлдвэрлэлийн хөгжил, хүн амын төвлөрөл, ажлын байрны эрэлт хэрэгцээг харгалзан, түүнчлэн нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулах, орон нутагт хүн амыг тогтвортой суурьших нөхцлийг хангах үүднээс дэд бүтцийн хөгжил, хөрөнгө оруулалтын бодлогоор говийн бүс болон нийслэл хот орчимд суурьшлын шинэ болон шинэчлэн хөгжүүлэх төвүүдийг хот байгуулалтын бодлогоор дэмжин хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

1. Монгол Улсын хүн амын өсөлтийн хэтийн тооцооноос харахад, хөдөлмөрийн насны хүн ам 2010-2015 онд 157.0 мянга, 2016-2021 онд 151.0 мянга, 2022-2030 онд 238.0 мянгаар тус тус өсөхөөр байгаа нь өсөн нэмэгдэж буй үйлдвэрлэлийн ажиллах хүчний ирээдүйн эрэлт хэрэгцээг хангах боломжтой юм. Гэхдээ мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжлийг зөвхөн хүний тоонд бус чанарт суурилах учраас одооноос дэлхийн түвшинд ажиллаж чадахуйц мэргэжлийн ажилтан бэлтгэх шаардлага тулгарч байна.
2. Уул уурхайн үйлдвэрлэл, дэд бүтцийн бүтээн байгуулалтын томоохон төслийг түшиглэж, манай орны өмнөд хэсэг, ялангуяа говийн бүсийн аймгийг чиглэх хүн амын шилжилт хөдөлгөөн улам нэмэгдэх төлөвтэй байна.
3. Ажилгүйдэл буурахгүй байгаа боловч нэг талаар мэргэжилтэй боловсон хүчний илүүдэл, нөгөө талаар ажлын байрны эрэлт хэрэгцээ нэмэгдсээр байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг төрийн бодлогоор зохицуулах шаардлагатайг харуулж байна. 2010 оны байдлаар улсын хэмжээгээр албан бусаар 100.0 гаруй мянган ажилгүйчүүд байхад 50.0 гаруй мянган ажлын байр чөлөөтэй байна.
4. Монгол улсын эдийн засгийн өнөөгийн хандлага уул уурхай, эрдэс баялаг, эрчим хүч, зам тээвэр, барилгын салбар руу чиглэсэн хандлагатай хөгжиж байхад их, дээд сургууль, коллежид суралцагчдын 62.0% хувь буюу 104720 нь нийгэм, хүмүүнлэг, боловсрол, үйлчилгээний салбарын чиглэлээр суралцаж байгаа нь өнөөгийн болон ойрын ирээдүйн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангахгүйд хүргэж байна.
5. Уул уурхай (Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сум, Эрдэнэт, Багануур хот), төмөр зам болон авто замын гол тэнхлэг дагасан (Улаанбаатар, Сайншанд, Даланзадгад, Дархан, Замын-үүд) зэрэг хот, суурин газрын хүн амын төвлөрөл 2004-2010 онд ихээр нэмэгдсэн, цаашид төвлөрөл нэмэгдэх хандлагатай байгаа нь эдгээр суурьшлын төвд хот байгуулалтын болон дэд бүтэц, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг хангах талаар нэгдсэн бодлого хэрэгжүүлэх, хүрээлэн буй орчин/цаг агаар, хөрс, ус, хот байгуулалт г.м/-ы судалгааг яаралтай хийх шаардлагатайг харуулж байна.
6. Өргөн удам нутаг дэвсгэртэй, хүн ам цөөнтэй боловч 21 аймаг, 330 суманд хуваагдаж, хүн ам хэт сарнин байршсан, Монгол улсын онцлогыг харгалзан

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

орон нутгийн татах хүчийг нэмэгдүүлэх татвар, хөрөнгө оруулалтын зохистой бодлого авч хэрэгжүүлэхгүй байгаагаас хөдөө орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, хөгжих нөхцөл бүрдэхгүй байгаа нь ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, хөдөөнөөс төв рүү чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн үргэлжилхэд хүргэж байна.


7. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 20.0 хувийг үйлдвэрлэж буй хөдөө аж ахуйн салбарын ажиллагсад нь нийт хүн амын 28.0 хувь, хөдөлмөр эрхлэгчдийн 34.0 хувийг эзэлж байгаа бөгөөд малчид, тариаланчдын хөдөлмөр сүүлийн үед хүчтэй ажиглагдах болсон дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд улам эмзэг болж байгаа учраас дэлхийн дулаарал, ган зудын давтамж, хохиролоос үүдэлтэй хөдөөнөөс хотыг зорих шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, хүн амын эмзэг давхаргыг нэмэгдүүлсээр байна.
8. Монгол улсын хүн амын өсөлт, нутагшилт, суурьшилтын 5-15 жилийн төлөв байдлаас харахад хүн ам зүйн бодлогоос шалтгаалан хүн амын өсөлтийн зогсонги байдал өөрчлөгдөж өсөлт нэмэгдэх, өмнөх жилүүдийн хүн амын өсөлтийн үр дүнд бий болсон хөдөлмөрийн насанд дэвших залуучуудын тоо нэмэгдэж, ажиллах хүчний эрэлт нэмэгдэх таатай орчин бүрдэж байна.
9. Ихэнх яам, агентлагт салбарын хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөр байхгүй, яам, агентлаг, аймаг, орон нутгийн ЗДТГ хоорондын ажлын уялдаа холбоо сул, холбогдох мэдээ, мэдээлэл зөрүүтэй, үйлдвэржилт, хүн амын нутагшилт, суурьшил, хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн бодлого хангалтгүй, хэрэгжүүлэх үйл ажиллагаа хоорондоо уялдаа холбоо муутай байна.

#### **4.2. Судалгааны зөвлөмж**

Монгол Улсын үйлдвэржилтийн хөгжил, төвлөрөлтэй уялдсан хүн амын нутагшилт суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлэхийн тулд цогц байдлаар тодорхой үе шатаар хэрэгжүүлэхээр хандах нь зайлшгүй юм. Тогтвортой хөгжил бүхий хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоонд хүрэх замын зургийг дараах байдлаар төсөөлж гаргалаа (Зураг № 27).

**Зураг № 27. Тогтвортой хөгжил бүхий хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд хүрэх замын зураг (roadmap)**

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.



Улмаар бидний санал болгосон Тогтвортой хөгжил бүхий хүн амын нутагшилт, суурьшлын хувилбарыг одоогийн урсгалаар явах хувилбартай харьцуулалт хийснийг Хүснэгт № 22-д үзүүлээ.

Хүснэгт № 24

### Хүн амын нутагшилт, суурьшил, хөдөлмөрийн зах зээлийн бодлогын хувилбар

Суурьшлын хэлбэр, төвүүд	Хувилбар 1. Одоогийн урсгалаар явах			Хувилбар 2. Тогтвортой хөгжил бүхий хүн амын нутагшилт суурьшил		
	2010	2016	2021	2010	2016	2021
Нийт хүн ам, мян.хүн (жилд 1.4%-иар өсөх)	2,754.0	3,035.0	3,254.0	2,754.0	3,035.0	3,254.0
Улаанбаатар хот	1,240.0	1,500.0	1,950.0	1,240.0	950.0	850.0
Шинэ Улаанбаатар – Airport city	0.0	0.0	0.0	0.0	25.0	150.0
Шивээтийн хөндий	0.0	0.0	0.0	0.0	110.0	150.0
ХАА-н сум, суурингууд	700.0	750.0	800.0	700.0	700.0	700.0
Өмнөговь аймаг	62.7	68.0	75.0	62.7	88.0	125.0
Даланзадгад	18.7	20.0	23.0	18.7	23.0	32.0
Ханбогд	9.6	12.0	15.0	9.6	25.0	65.0
Цогтцэций	7.7	8.5	10.1	7.7	15.0	28.0
Шинэ төв (Ханбогд, Цогтцэцийн )	17.3	25.0	35.0	17.3	40.0	95.0
Сайншанд	18.6	205.0	23.0	18.6	35.0	65.0
Замын-Үүд	9.5	12.0	15.0	9.5	15.0	25.0
Хархорин	13.0	14.0	15.0	13.0	16.0	22.0

Судалгааны дүнд үндэслэн дараахи арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. үүнд:

1. Хүн амын нутагшилт, хөгжлийн хүрээнд Монгол орны байгаль, цаг уурын нөхцөл, эрдэс баялгийн нөөц, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, хүрээлэн буй байгаль хамгаалал, тухайн төв суурингийн суурьшлын өвөрмөц онцлог, цаашдын хөгжлийн төлөвийг тодорхойлсон “Монгол Улсын хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулж батлах;

2. Хөшигийн хөндийн Нисэхийн хотхон, Оюутны хотхон гэсэн нийслэлийн хоёр дагуул хот, Тавантолгой, Оюутолгойн уурхайг түшиглэсэн говийн бүс шинэ хот (2 дахь Эрдэнэт хот) гэсэн суурьшлын 3 шинэ төв, Дархан, Сайншанд, Замын-Үүд, Ховд, Улиастай, Чойбалсан, Арвайхээр төвийг шинэчлэн хөгжүүлэхэд эн тэргүүнд ач холбогдол өгч, хүн амын нутагшилт, суурьшил, хот байгуулалтын бодлогоор хөгжүүлэх;

3. Шинээр үүсэх болон шинэчлэн өөрчлөгдөх хот, сууринд өрхийн аж ахуй, эрүүл мэндийн үйлдлээр төвөөс алслан суурьших сонирхолтой иргэдэд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, газар тариалан, өрхийн аж ахуй эрхлэхэд нь дэмжлэг болгож ахуйн ба нийгмийн дэд бүтэц, хашаа газрыг ерөнхий төлөвлөгөөний дагуу барьж байгуулах ажлыг зохион байгуулах,

4. Бүсчилэн хөгжүүлэх асуудлыг эрчимжүүлэн эхний шатанд Баруун бүсээс эхлэн ээлж дараатай хөрөнгө оруулалт хийж бүсийн хөтөлбөр, бүсийн удирдлагыг идэвхтэй дэмжих,

5. Алслагдсан аймаг сумдаас нийслэл хотод нүүж ирсэн гэр хорооллын голдуу айл өрхийг аж ахуй эрхлэх мэт тодорхой болзолтойгоор нутагтай буцан суурьшихад нь эдийн засгийн урамжуулал “40-50” сая төгрөгийн хэмжээнд үзүүлэх,

6. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5.0-10.0 хүртэл хувийг хүн амын суурьшлын шинэ болон шинэчлэн хөгжүүлэх төвүүдийн бүтээн байгуулалтад зарцуулах эрх зүйн орчин бий болгох;

7. Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын өнөөгийн байдалд иж бүрэн үнэлэлт дүгнэлт хийсний үндсэн дээр хүн амын хэт төвлөрлийг сааруулах, суурьшлын шинэ төвүүдийг дэмжих, уул уурхай болон олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэсэн шинэ хот байгуулалтыг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

8. Стратегийн орд газар, томоохон үйлдвэржилтийн бүсийн асуудлыг шийдвэрлэхдээ Эрдэнэт хотын жишгээр хот төлөвлөлт, хүн амын нутагшилт, сууршилт, хөдөлмөр эрхлэлт, дэд бүтцийн хэтийн бодлогын асуудалтай нь иж бүрэн шийдвэрлэхэд чиглэсэн төрийн бодлого баримтлах. (Тухайлбал тэдгээр уурхайг эзэмшигч талуудтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд энэ асуудлыг тодорхой тусгаж өгөх нь зүйтэй.)

9. Сургалтын байгууллагад төрөөс олгож байгаа санхүүжилтийг үр ашигтай зарцуулах, сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулах, төрийн сангаас олгож байгаа санхүүжилтийн үр өгөөжийг дээшлүүлэх, ажил олгогч, аж ахуйн нэгжийн эрэлт, захиалгаар сургалт явуулах, хэрэгцээт мэргэжлийн чиглэлээр захиалагч байгууллага, сургуулиуд хамтарсан тэтгэлэгт сургалтын хэлбэрт шилжих,

10. Монгол улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын мэргэжилтэн, ажилтнуудын залгамж халаа болгон монгол ажилтныг сургаж бэлтгэх үүднээс гадаадын мэргэжилтнийг урт хугацаагаар ажиллуулахгүй байх, ажиллах хугацаандаа монгол ажилтныг бэлтгэж сургах тогтолцоо бий болгох ,

Энэхүү судалгаа нь ҮХШХ-ны өмч болно.

11. Хүн амын нутагшилт, суурьшлын хүрээнд Монгол орны байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон хот байгуулалтын норм, нормативыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

12. Уул уурхайн салбарын их орлогоор бүтээн байгуулах уул уурхайн үйлдвэрлэл, дэд бүтэц, хот байгуулалтын салбарт ойрын ирээдүйд ажиллах гадаад, дотоодын ажиллагсдын иж бүрэн, нарийвчилсан судалгааг 2012 онд багтаан хийх.

13. Тухайн мэргэжлээр төгсөгчдийн 70-аас дээш хувь нь ажил эрхлээгүй байгаа мэргэжлийн чиглэлийн элсэлтийг түр зогсоох, энэ чиглэлээр хүүхдийнхээ сургалтын зардалд зээл авах хүсэлтэй иргэдэд бодит зөвлөлгөө өгөх талаар Банкны байгууллагуудад нэгдсэн чиглэл өгөх.

14. Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн багтаамжийг харгалзан эхний ээлжинд ижил төрлийн мэргэжил олгодог Төрийн өмчийн сургуулиудын мэргэжлийн чиглэлийг нэгтгэн төрөлжүүлэх замаар сургалтын чанар үр ашгийг сайжруулах арга хэмжээ авах

15. Одоогийн эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, хөдөлгөөнд оруулах асуудлыг судлан үзэх, судалгааны багаас санал болгож буй ОХУ, БНХАУ, Монгол улс гурвын хилийн зааг бүсэд хамтарсан чөлөөт бүс байгуулах асуудлыг судлан үзэж хөрш орнуудтай санал солилцож хамтран ажиллах/ Дорнод аймаг гурван улсын хилийн зааг/

**Зураг 28. Хүн амын суурьшлын тэргүүлэх төвүүдийн хэтийн төлөв**

